

Өвөрхангай аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн 2002 оны гүйцэтгэлийн талаарх танилцуулга

Нэг: Нийгэм

Хүн ам

2002 оны байдлаар Өвөрхангай аймаг 109316 хүн амтай, үүнээс эрэгтэй 53984, эмэгтэй 55332 хүн байна. Энэ онд 2146 хүүхэд төрж, 650 хүн нас барж, УБ болон бусад аймаг хотруу 2294 хүн шилжиж, 239 хүн шилжиж ирсэн байна. Нийт хүн амын 59758 нь буюу 54.6 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам, 41408 нь буюу 37.9 хувь нь хүүхэд, 8150 нь буюу 7.4 хувь нь өндөр настан байна. Хөдөлмөрийн насны хүн амын 45.6 мянган хүн нь өмчийн аль нэг аж ахуйн нэгж, цэг салбарт ажил хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлээгүй 10.0 мянга гаруй хүн байгаагийн, 2137 нь хөдөлмөр зохицуулалтын албанд албан ёсоор бүртгүүлж ажил шуурхай хайж байгаа хүмүүс байна. Аймгийн хөдөлмөрийн насны 1000 хүнд 835 тэжээвэр хүн ноогдож байна.

Аймаг 28278 өрхтэй. Өрхийн 37.4 хувь нь сумын төвд, 62.6 хувь нь хөдөөд оршин суудаг.

Боловсрол

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын бага, дунд 30 сургуульд 820 багш ажиллаж, 678 бүлэгт 21326 сурагч суралцаж байна. Аймгийн дүнгээр авч үзвэл: 1 бүлэгт 30.4 сурагч ноогдож байгаа боловч Арвайхээр сумын 1.2-р 10 жилийн сургуульд 37.0-39.0 хүүхэд ноогдож байгаа нь дундчаас 7.1-7.2 сурагчаар их байна. Сургуулийн дотуур байрнуудад 2226 хүүхэд амьдарч байна. Сургуулийн өмнөх насны 28 байгууллагад 2995 хүүхэд хүмүүжиж байна.

Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд нэгдсэн эмнэлэг 1, сум дундын эмнэлэг1, их эмчийн салбар 17, бага эмчийн салбар 69, эмийн сан 22 ажиллаж, тэдгээрт их эмч 165, эмийн дээд мэргэжилтэн 7, дунд мэргэжилтэн 434, ажиллаж 1 их эмчид 663 хүн, 1 дунд мэргэжилтэнд 245 хүн тус тус ноогдож байна.

Гэмт хэрэг

2002 онд 690 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оныхоос 83 хэргээр буурсан байна. Бусдыг санаатай алсан хэрэг 7 гарч өмнөх оныхоос 3-р буурчээ. Нийт гэмт хэргийн дотор иргэдийн өмчийн хулгай 54.2 хувийг эзэлж байна. Хэрэг үйлдэгчдийн тоо 629 байгаагийн 358 нь буюу 56.9 хувь нь 18-35 насны залуучууд байна. Гэмт хэргийн улмаас иргэдэд 349.6 сая, төгрөгийн хохирол учирсан байна.

Хоёр: Эдийн засаг

Төсөв санхүү

2002 онд аймгийн төсвийн нийт орлого 1923.3 сая болж, төлөвлөгөөний биелэлт 119.0 хувиар хангагдсан. Үүний 1454.4 сая төгрөг нь буюу 75.7 хувь нь татварын орлого, 468.9 сая төгрөг буюу 24.3 хувь нь татварын бус орлого эзэлж байна. Нийт орлогын 18.6 хувийг өөрийн орлого эзэлдэг. Татварын орлогын 47.7 хувийг онцгой албан татвар, НӨАТ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зарлага 6161.1 сая төгрөг болсны 50.1 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, 2.0 хувийг эрүүл мэндийн даатгал, 42.6 хувийг бараа үйлчилгээ, 3.8 хувийг хөрөнгө оруулалт, их засварын зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

Аймгийн сум, төсөвт газрууд төсвийн өргүй гарсан байна.

Аймгийн нийгмийн даатгалын сангуудын орлого 3356.3 сая төг болж төлөвлөгөө 107.0 хувиар биелэгдсэн байна. Бүх төрлийн тэтгэвэрт 2894.6 сая төг, тэтгэмжид 107.3 сая төгрөг олгохоос 100.0 хувь олгожээ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд 922.6 сая төгрөг зарцуулсан байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ

2001 онд аймгийн татварын албанд албан ёсоор бүртгэлтэй 316 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: ОНӨААҮГ-3, ТӨҮГ-4, ХК-18, ХХК-132, нөхөрлөл-52, хоршоо-45, ХЭАА-56 байна.

Хөдөө аж ахуй

2002 оны эцэст аймгийн мал 1665362 толгой болсон байна. Үүнээс тэмээ 13339, адуу 115145, үхэр 75256, хонь 805935, ямаа 655687, толгой болсон дүн мэдээ гарлаа. Нийт малын 41.5 хувь нь хээлтэгч мал эзэллээ.

Энэ онд 462.0 мянган төл бойжиж, 222.8 мян.мал хорогдсон. Аймгийн хэмжээгээр малтай өрх 20578 байгаагийн 1972 нь 10 хүртэл толгой малтай, 4077 өрх 11-30 толгой малтай, 3556 өрх 31-50 толгой малтай, 5297 өрх 51-100 толгой малтай, 3914 өрх 101-200 толгой малтай, 1576 өрх 201-500 толгой малтай, 93 өрх 501-999 толгой малтай, 11 өрх 1000-аас дээш малтай байна. Малтай өрхөөс 1263 өрх авто машинтай, 3397 өрх мотоцикльтой, 87 өрх трактортой, 3829 өрх цахилгаан үүсгэвэртэй, 3824 өрх телевизортой байна. Малчид энэ онд 31.8 мян.метр эсгий хийжээ.

Аймгийн хэмжээнд 3258.6 га-д үр тариа, 168.1 га-д төмс, 83.0 га-д хүнсний ногоо тариалж, үр тариа 775.9 тн, төмс 942.5 тн, хүнсний ногоо 423.1 тн-ыг хураан авсан байна. Малчид 12.9 тн байгалийн хадлан, 3.0 мянган тн гар тэжээл бэлтгэжээ.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгж, цэг салбарууд 1931.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1849.7 сая.төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт үйлдвэрлэлтэд хүнснийх 58.4 хувь, цахилгаан дулааных 22.2 хувь, нүүрснийх 18.8 хувь, мод модон эдлэл 2.4 хувь, хэвлэлийнх 0.4 хувь, бусад үйлдвэрлэл 1.8 хувийг тус тус эзэлж байна.

Барилгын аж ахуйн нэгжүүд 370.0 сая төгрөгийн барилга угсаралт их засварын ажил хийлээ. Тээврийн үйлчилгээ эрхлэдэг аж ахуйн нэгж, иргэд 6034.2 тн ачаа, 71.0 мян. хүн тээврийн үйлчилгээ явуулж 106.2 сая.төгрөгийн орлого олсон байна.

Худалдаа эрхлэдэг аж ахуйн нэгж, цэг салбарууд 1378.8 сая.төгрөгийн бараа борлуулалт хийжээ. Аймгийн төвийн зочид буудлууд 29.5 сая төгрөгийн орлого үйлчилгээ олсон байна.

Гурав: Байгаль орчин

Аймаг нийтдээ 6289533.0 га нутаг дэвсгэртэй. Үүний 5960721.6 га нь Хөдөө аж ахуйн газар байдаг. Үүнээс 591320710.3 га-д бэлчээрийн, 6819.8 га-д хадлангийн, 5756.1 га-д тариалангийн, 33529.7 га нь атаршсан талбай эзэлдэг. Нийт талбайн 278727 га-д ойн сан, 4922.0 га-д усан сан бүхий талбайнууд байдаг. Нийт 104419 га га талбай бүхий үзэсгэлэнт 10 газар тусгай хамгаалалтанд байдаг. Мэргэжлийн байгууллагуудын сүүлийн үеийн хийсэн судалгаанаас үзэхэд тарвага 522.5 мян.толгой, бор гөрөөс 2090 толгой, аргал 1590 толгой, янгир 3314 толгой, буга 2710 толгойн нөөцтэй гэсэн мэдээ гаргасан байна.

Статистикийн Хэлтэс